



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 05-

Арвайхээр


Шагналд уламжлах тухай

Төрийн албаны зөвлөлийн “Журам батлах тухай” 2013 оны 71 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнах журмын 3.2, “Тав” дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Салбар зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн I хуралдааны шийдвэрийг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Ганболд, Мэргэжлийн хяналтын газрын дарга С.Дуламсүрэн, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн Р.Наранцэцэг, Хужирт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Д.Төмөр нарыг “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнуулах тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлд уламжилсугай.

2. “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнуулах дээрх төрийн албан хаагчдын шагналын материалыг журмын дагуу бүрдүүлж, Салбар зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн хамт Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (Э.Бадамгэрэл)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНБОЛД